

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ.....	2
2	Аудитын тайлан	4
2.1	Оршил.....	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	8
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11	Шилэн дансны мэдээлэл	8
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	8
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3	Менежментийн захидал.....	10
4	Аудит хийгдсэн тайлан.....	13
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	13
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	14
4.3	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	16
4.4	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	17
4.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	19
4.6	Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	20
5	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ЗАМЫН-ҮҮДИЙН ЧӨЛӨӨТ БҮСИЙН
ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ЗАХИРАГЧ И.БАТНАСАН ТАНАА

2019.02.25 № 06/225
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Замын-Үүдийн Чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Замын-Үүдийн Чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Замын-Үүдийн Чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Замын-Үүдийн Чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Замын-Үүдийн Чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны Захирагч И.Батнасан Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Замын-Үүдийн Чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Замын-Үүдийн Чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрөөс 2019 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Тэд-Аудит” ХХК-ийн аудитор Г.Эрдэнэчимэг хариуцаж хэрэгжүүлэв.

Замын-Үүдийн Чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг "Тэд-Аудит" ХХК-д 2019 оны 01 дүгээр сарын 25-нд 01/113 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБООУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБООУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНБООУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Замын-Үүдийн Чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Замын-Үүдийн Чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба нь Олон Улсын жишигт нийцсэн чөлөөт бүсийг байгуулж хөгжүүлснээр Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулах гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагааны чиглэл, зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Засгийн газрын 2004 оны 45 дугаар тогтоолоор Замын-Үүдийн Чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба нь "Замын-Үүд" Эдийн Засгийн Чөлөөт бүсийг байгуулж, хөгжүүлэхэд төрийн бодлогыг чиглүүлж ажиллажээ.

Замын-Үүдийн Чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Замын-Үүдийн Чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Замын-Үүдийн Чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Замын-Үүдийн Чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Винициа” програм хангамж ашигладаг байна.

Замын-Үүдийн Чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “**Дунд**” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Замын-Үүдийн Чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 9 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 9 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны нийт зардлын 1 хувиар сонгов.

2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь АОУС 320-ын дагуу тодорхойлсонтой холбоотой юм.

Замын-Үүдийн Чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны нийт зардал 1,181,811.0 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 11,818.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь байгууллагын хамрах хүрээ хязгаарлагдмал, санхүүжилтийн хэмжээ бага, өөрийн орлого байхгүй, гарч болох эрсдэл бага гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 9 чиглэлээр аудитын горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 5 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцов.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	5	882,934.4	/мянган төгрөгөөр/
	Дүн	5	882,934.4	

2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Замын-Үүдийн Чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба нь аж ахуйн нэгж байгууллагуудад төсөл сонгон шалгаруулах хэлбэрээр газар эзэмшүүлж, газрын төлбөр болох нийт 502,999.0 мянган төгрөгийг гүйцэтгэлээр нь тайлант жилд Төрийн сангийн 100900036011 тоот урсгал зардлын санхүүжилтийн дансанд хамт төвлөрүүлж төсвийн гүйцэтгэлийн тайланд буруу илэрхийлж байгааг аудитаар тусад нь данс нээж, бүртгэх талаар зөвлөмж өгсөн. Энэхүү алдаа зөрчлийг дараагийн аудитаар мөнгөн хөрөнгийн дансанд нарийвчилсан горим, сорилыг хэрэгжүүлж ажиллана гэж үзлээ.

Мөн нийт санхүүжилт 968,276.8 мянган төгрөг ба үүний 465,376.8 мянган төгрөг нь цэвэр санхүүжилт харин төлөвлөгөөгүй 502,999.0 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн тайланд үндсэн үйл ажиллагааны орлогын гүйцэтгэлээр тайлагнасан байгааг дараагийн аудитаар анхаарах нь зүйтэй.

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Замын-Үүдийн Чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотойгоор тайлант жилд нийт 465,376.8 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 461,285.2 мянган төгрөгийг зарцуулж, 4,091.5 мянган төгрөгийг хэмнэж 99.1 хувийн гүйцэтгэлтэй байна.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Замын-Үүдийн Чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Замын-Үүдийн Чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Замын-Үүдийн Чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Замын-Үүдийн Чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг бус хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Дотоод аудит хяналт, шинжилгээ үнэлгээний талаар

3.1.1 Илрүүлэлт:

Тус захирагчийн албанд хяналт, шинжилгээ үнэлгээ, дотоод аудит хариуцсан орон тооны албан тушаалтан ажилладаг сайн талтай бөгөөд харин тайлант жилд хийсэн дотоод аудитын тайлангаас харахад эрсдэлүүдийг төлөвлөлтийн шатанд тодорхойлоогүй, дотоод аудитын тайлангийн загвараар тайлан бичээгүй, өгч байгаа зөвлөмжүүд нэгж, албадуудын холбогдох албан тушаалтнуудад нэр зааж өгдөггүй, дотоод аудит хийх ажил бүр дээр аудитын төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулж батлуулж ажиллаагүй, бүтэц зохион байгуулалтын хувьд хараат бус зарчим алдагдаж байгаа зэрэг нь Дотоод аудитын мэргэжлийн практикийн Олон Улсын стандарт (ДАМПОУС) болон Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан "Дотоод аудитын дүрэм"-ийн 3.1, 4.4, 7.2, 7.3 дахь заалтуудыг тус тус зөрчиж байна.

3.1.2 Эрсдэл:

Байгууллагын дотоод хяналт сул байх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Дотоод аудитын мэргэжлийн практикийн Олон Улсын стандарт (ДАМПОУС) болон Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан "Дотоод аудитын дүрэм"-ийг үндэслэн байгууллагын онцлогт уялдуулан дүрэм журмыг боловсруулж батлуулан түүнийг мөрдөж ажиллах

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг засч залруулж ажиллах болно.

3.2 Үйл ажиллагааны орлогын талаар

3.2.1 Илрүүлэлт:

Чөлөөт бүсийн тухай хууль болон Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 291 дүгээр тогтоолыг үндэслэн Захирагчийн алба аж ахуйн нэгж байгууллагуудад төсөл сонгон шалгаруулах хэлбэрээр газар эзэмшүүлж, газрын төлбөр авч байна. Энэхүү оруулсан орлого батлагдсан төлөвлөгөө байхгүй, зөвхөн урсгал зардлын санхүүжилтын 100900036011 тоот дансанд тайлант жилд нийт 502,999.0 мянган төгрөг төвлөрүүлж, Сангийн яамны Төрийн санд төвлөрүүлжээ. Ийнхүү урсгал санхүүжилтийн дүнд оруулан бүртгэж байгаа нь төсвийн тухай хуулиар баталсан төсвийг хэтрүүлсэн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг буруу илэрхийлэхэд хүргэж байна.

3.2.2 Эрсдэл:

Үйл ажиллагааны орлогыг үнэн зөв ангилж бүртгээгүй байх

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Чөлөөт бүсийн тухай хуулийн 19.1.3-т зааснаар энэхүү газрын төлбөрийн орлогыг “Аж ахуйн үйл ажиллагааны орлого” гэж үзэж Захирагчийн алба нь улсын төсөвт төвлөрүүлэхээр заасныг үндэслэн тусгай данс нээж төвлөрүүлэн бүртгэлд тусгах

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг засч залруулж ажиллах болно.

3.3 Санхүүгийн тайлагналын талаар

3.3.1 Илрүүлэлт:

Санхүүгийн тайлангийн тодруулгыг хагас дутуу хийж байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8.1.5 дахь заалт болон АОУС 700-ын 14 (а, б) дэх зүйлд заасан “**Санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга**”-ыг үнэлэх боломжгүй болгож байна.

3.3.2 Эрсдэл:

УСНББОУС-1 болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль зөрчих, санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүн дутуу байх

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн тайлангийн тодруулгыг УСНББОУС 1-ын шаардлага, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан тодруулгын зааврын дагуу бүрэн гаргаж байх

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг засч залруулж ажиллах болно.

3.4 Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн талаар

3.4.1 Илрүүлэлт:

Сангийн сайдын 2012 оны 76 дугаар тушаалаар баталсан “Төсвийн гүйцэтгэлийн тайлан боловсруулах журам”-ын дагуу 2.3, 2.5-д заасны дагуу Төсөвт байгууллага нь төсвийн гүйцэтгэлийн тохируулгыг маягтын дагуу үнэн зөв гаргаж баталгаажуулахаар заасны дагуу зөв гаргахгүй байна.

3.4.2 Эрсдэл:

Төсвийн гүйцэтгэлийн тайланг үнэн зөв гаргаагүй байх

3.4.3 Өгсөн зөвлөмж:

“Төсвийн гүйцэтгэлийн тайлан боловсруулах журам”-ын дагуу 2.3, 2.5-д заасны дагуу Төсөвт байгууллага нь төсвийн гүйцэтгэлийн тохируулгын тайланг үнэн зөв гаргаж санхүүгийн тайланд хавсаргаж байх

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг засч залруулж ажиллах болно.

3.5 Үндсэн хөрөнгийн талаар

3.5.1 Илрүүлэлт:

Замын-Үүдийн чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт 2008 онд Улсын төсвийн хөрөнгөөр 6 урсгалтай, 1.25 км хатуу хучилттай авто зам тавихад зарцуулж, одоогийн байдлаар ажил бүрэн дуусч 100 хувийн гүйцэтгэлтэй гэх боловч Улсын комисс албан ёсоор хүлээж аваагүй, өмчлөлийн асуудал шийдэгдээгүй, нягтлан бодох бүртгэлд 379.9 сая төгрөгийн “Дуусаагүй барилга байгууламж”-аар бүртгэсээр иржээ. Энэ нь УСНББОУС болон Сангийн сайдын 2016 оны 388 дугаар тушаалаар баталсан “Санхүүгийн тайлангийн аргачлал, зааврыг зөрчсөн байна.

3.5.2 Эрсдэл:

Хөрөнгө иж бүрэн, үнэн зөв бүртгээгүй байх

3.5.3 Өгсөн зөвлөмж:

Хөрөнгийг хүлээн авах, эзэмшүүлэх, өмчлөх талаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах талаар арга хэмжээ авч ажиллах

3.5.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг засч залруулж ажиллах болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 06 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан /төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>5,658,625.00</u>	<u>5,218,661.00</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
34	УРЬДЧИЛГАА	67,077.43	-
34600	Урьдчилж гарсан зардал	67,077.43	
35	БАРАА МАТЕРИАЛ	5,591,547.57	5,218,661.00
354	Хангамжийн материал	5,591,547.57	5,218,661.00
35410	Бичиг хэргийн материал	1,728,505.57	978,319.00
35470	Бусад хангамжийн материал	3,863,042.00	4,240,342.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,494,184,661.77</u>	<u>2,963,664,356.12</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,494,184,661.77	2,963,664,356.12
391	Газар		454,500,000.00
392	Биет хөрөнгө	2,526,675,150.04	1,651,325,165.76
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,789,466,475.00	869,306,722.20
39202	Хуримтлагдсан элэгдэл	-678,528,073.52	-
39203	Авто-тээврийн хэрэгсэл	67,814,635.16	67,814,635.16
39204	Хуримтлагдсан элэгдэл	-67,814,635.16	-67,814,635.16
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	115,213,738.24	106,483,738.24
39206	Хуримтлагдсан элэгдэл	-79,412,448.68	-85,222,909.98
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	21,554,717.46	19,593,140.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	-21,554,717.46	-19,593,140.40
39214	Бусад үндсэн хөрөнгө		385,040,606.96
39215	Хуримтлагдсан элэгдэл		-4,218,450.66
39216	Дуусаагүй барилга, байгууламж	379,935,459.00	379,935,459.00
393	Биет бус хөрөнгө	967,509,511.73	857,839,190.36
39301	Програм хангамж	3,287,000.00	3,287,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-3,172,187.23	-3,172,187.23
39303	Бусад биет бус хөрөнгө	1,349,806,857.00	1,349,806,857.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-382,412,158.04	-492,082,479.41
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>3,499,843,286.77</u>	<u>2,968,883,017.12</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>1,050,000.00</u>	<u>1,050,000.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,050,000.00	1,050,000.00
414	Урьдчилж орсон орлого	1,050,000.00	1,050,000.00
41440	Бусад урьдчилж орсон орлого	1,050,000.00	1,050,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>3,498,793,286.77</u>	<u>2,967,833,017.12</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	3,498,793,286.77	2,967,833,017.12
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,350,798,876.02	1,350,798,876.02
51101	Өмч: - төрийн	1,350,798,876.02	1,350,798,876.02
512	Хуримтлагдсан үр дүн	2,136,419,029.60	1,923,204,564.37
51210	Өмнөх үеийн үр дүн	2,136,419,029.60	2,136,419,029.60
51220	Тайлант үеийн үр дүн		-213,214,465.23
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	11,575,381.15	-306,170,423.27
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>3,499,843,286.77</u>	<u>2,968,883,017.12</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,710,971,959.00	968,596,600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,213,315,357.00	503,197,800.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,213,315,357.00	503,197,800.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,213,315,357.00	503,197,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	432,508,500.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		503,197,800.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	780,806,857.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	497,656,602.00	465,398,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	488,553,300.00	465,398,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	488,553,300.00	465,398,800.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	9,103,302.00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	9,103,302.00	
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,129,424,253.07	1,181,811,065.23
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,129,424,253.07	1,181,811,065.23
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	637,208,967.51	674,499,763.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	293,364,494.99	310,735,752.62
210101	Үндсэн цалин	265,862,294.99	283,233,552.62
210102	Нэмэгдэл	27,502,200.00	27,502,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,995,731.75	37,210,932.17
210201	Тэтгэврийн даатгал	21,024,872.50	24,956,232.17
210202	Тэтгэмжийн даатгал	3,003,553.37	3,063,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,402,842.50	2,450,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	600,710.64	612,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,963,752.74	6,127,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,215,561.00	46,536,401.00
210301	Гэрэл, цахилгаан	26,491,568.00	29,428,069.00
210302	Түлш, халаалт	13,630,793.00	15,676,732.00
210303	Цэвэр, бохир ус	3,093,200.00	1,431,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,291,829.00	14,216,424.80
210401	Бичиг хэрэг	3,127,284.30	3,513,253.00
210402	Тээвэр, шатахуун	3,535,000.00	3,535,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,628,417.70	4,169,626.80
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,001,127.00	2,998,545.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,608,094.00	12,740,000.00
210604	Урсгал засвар	18,608,094.00	12,740,000.00
2107	Томилолт, зочны зардал	7,583,610.00	7,586,302.00
210702	Дотоод албан томилолт	7,583,610.00	7,586,302.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,794,880.00	31,659,450.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	22,513,300.00	26,261,030.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,980,000.00	1,980,000.00

Замын-Үүдийн Чөлөөт бүсийн Захирагчийн Ажлын албаны 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210803	Даатгалын үйлчилгээ	626,505.00	723,240.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	234,975.00	280,580.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,629,000.00	1,633,500.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	781,100.00	781,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	200,354,766.77	213,814,501.23
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,045,000.00	1,040,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	199,309,766.77	212,774,501.23
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	492,215,285.56	507,311,301.41
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	37,334,002.00	-
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	8,999,302.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	28,334,700.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	454,881,283.56	507,311,301.41
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	454,881,283.56	507,311,301.41
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>581,547,705.93</u>	<u>(213,214,465.23)</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>581,547,705.93</u>	<u>(213,214,465.23)</u>

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>930,165,102.00</u>	<u>968,596,600.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	432,508,500.00	503,197,800.00
120	Нийтлэг татварын бус орлого	432,508,500.00	503,197,800.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	432,508,500.00	503,197,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	432,508,500.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		503,197,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	497,656,602.00	465,398,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	488,553,300.00	465,398,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	488,553,300.00	465,398,800.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	9103302.00	0.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	9103302.00	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>930,165,102.00</u>	<u>968,596,600.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	930,165,102.00	968,596,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	437,845,816.44	461,285,298.59
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	292,659,726.74	313,384,984.79
210101	Үндсэн цалин	235,153,426.74	255,878,684.79
210102	Нэмэгдэл	27,502,200.00	27,502,200.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	30,004,100.00	30,004,100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,700,500.00	34,561,700.00
210201	Тэтгэврийн даатгал	21,445,772.72	22,307,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,450,945.48	3,063,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,063,681.81	2,450,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	612,736.36	612,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,127,363.63	6,127,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,215,561.00	46,536,401.00
210301	Гэрэл, цахилгаан	26,491,568.00	29,428,069.00
210302	Түлш, халаалт	13,630,793.00	15,676,732.00
210303	Цэвэр, бохир ус	3,093,200.00	1,431,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,238,444.70	13,776,460.80
210401	Бичиг хэрэг	3,073,900.00	3,073,289.00
210402	Тээвэр, шатахуун	3,535,000.00	

Замын-Үүдийн Чөлөөт бүсийн Захирагчийн Ажлын албаны 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

			3,535,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,628,417.70	4,169,626.80
210404	Ном, хэвлэл	3,001,127.00	2,998,545.00
2105	Нормативт зардал	0.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,608,094.00	12,740,000.00
210604	Урсгал засвар	18,608,094.00	12,740,000.00
2107	Томилолт, зочны зардал	7,583,610.00	7,586,302.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	7,583,610.00	7,586,302.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,794,880.00	31,659,450.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	22,513,300.00	26,261,030.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,980,000.00	1,980,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	626,505.00	723,240.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	234,975.00	280,580.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,629,000.00	1,633,500.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	781,100.00	781,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,045,000.00	1,040,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,045,000.00	1,040,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	492,319,285.56	507,311,301.41
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	37,334,002.00	0.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	8,999,302.00	
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,315,700.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,019,000.00	
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	454,985,283.56	507,311,301.41
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	454,985,283.56	507,311,301.41
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	=====	=====
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан /төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2017 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	1,350,902,876.02	11,575,381.15	1,554,871,323.67	2,917,349,580.84
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-104,000.00			-104,000.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,350,798,876.02	11,575,381.15	1,554,871,323.67	2,917,245,580.84
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0			0
Тайлант үеийн үр дүн			581,547,705.93	581,547,705.93
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,350,798,876.02	11,575,381.15	2,136,419,029.60	3,498,793,286.77
2018 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	1,350,798,876.02	11,575,381.15	2,717,966,735.53	3,498,793,286.77
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,350,798,876.02	11,575,381.15	2,136,419,029.60	3,498,793,286.77
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0	-317,745,804.42		-317,745,804.42
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0
Тайлант үеийн үр дүн			-213,214,465.23	-213,214,465.23
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,350,798,876.02	-306,170,423.27	1,923,204,564.37	2,967,833,017.12

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан /төгрөгөөр/

Үзүүлэлт	Тайлант оны			
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү (+, -)	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	465,376,800.00	461,285,298.59	4,091,501.41	99.1
УРСГАЛ ЗАРДАЛ	465,376,800.00	461,285,298.59	4,091,501.41	99.1
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	465,376,800.00	461,285,298.59	4,091,501.41	99.1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	314,613,700.00	313,384,984.79	1,228,715.21	99.6
Үндсэн цалин	257,107,400.00	255,878,684.79	1,228,715.21	99.5
Нэмэгдэл	27,502,200.00	27,502,200.00	-	100.0
Унаа хоолны хөнгөлөлт	30,004,100.00	30,004,100.00	-	100.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,561,700.00	34,561,700.00	-	100.0
Тэтгэврийн даатгал	21,993,800.00	22,307,000.00	(313,200.00)	101.4
Тэтгэмжийн даатгал	3,142,000.00	3,063,700.00	78,300.00	97.5
ҮОМШӨ-ний даатгал	2,513,500.00	2,450,900.00	62,600.00	97.5
Ажилгүйдлийн даатгал	628,400.00	612,700.00	15,700.00	97.5
Эрүүл мэндийн даатгал	6,284,000.00	6,127,400.00	156,600.00	97.5
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48,977,100.00	46,536,401.00	2,440,699.00	95.0
Гэрэл, цахилгаан	29,432,500.00	29,428,069.00	4,431.00	100.0
Түлш, халаалт	16,457,800.00	15,676,732.00	781,068.00	95.3
Цэвэр, бохир ус	3,086,800.00	1,431,600.00	1,655,200.00	46.4
Хангамж, бараа материалын зардал	13,814,100.00	13,776,460.80	37,639.20	99.7
Бичиг хэрэг	3,074,800.00	3,073,289.00	1,511.00	100.0
Тээвэр, шатахуун	3,535,700.00	3,535,000.00	700.00	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,185,600.00	4,169,626.80	15,973.20	99.6
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,018,000.00	2,998,545.00	19,455.00	99.4
Нормативт зардал	-	-	-	
Эд хогшил, урсгал засварын зардал	12,742,300.00	12,740,000.00	2,300.00	100.0
Урсгал засвар	12,742,300.00	12,740,000.00	2,300.00	100.0
Томилолт, зочны зардал	7,586,400.00	7,586,302.00	98.00	100.0
Дотоод албан томилолт	7,586,400.00	7,586,302.00	98.00	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,033,900.00	31,659,450.00	374,450.00	98.8
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	26,512,700.00	26,261,030.00	251,670.00	99.1
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,980,000.00	1,980,000.00	-	100.0
Даатгалын үйлчилгээ	736,600.00	723,240.00	13,360.00	98.2
Тээврийн хэрэгслийн татвар	324,700.00	280,580.00	44,120.00	86.4

**Замын-Үүдийн Чөлөөт бүсийн Захирагчийн Ажлын албаны 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

Тээврийн хэрэгслийн оношлогоо	65,300.00	-	65,300.00	0.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,633,500.00	1,633,500.00	-	100.0
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	781,100.00	781,100.00	-	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	1,047,600.00	1,040,000.00	7,600.00	99.3
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,047,600.00	1,040,000.00	7,600.00	99.3
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	465,376,800.00	465,376,800.00	-	100.0
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	465,376,800.00	465,376,800.00	-	100.0
Улсын төсвөөс санхүүжих	465,376,800.00	465,376,800.00	-	100.0
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.0
Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.0
Төсвөөс гадуур байгууллага			-	
АЖИЛЛАГСАДЫН ТОО	41.00	32.00	9.00	78.0
Удирдах ажилтан	7.00	7.00	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	31.00	22.00	9.00	71.0
Үйлчлэх ажилтан	3.00	3.00	-	100.0
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	41.0	36.0	5.00	87.8
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	34.0	29.00	5.00	85.3
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	7.0	7.00	-	100.0

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	0.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	0.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	0.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	0.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	0.00
2105	Нормативт зардал	0.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	0.00
2107	Томилолт, зочны зардал	0.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	0.00
211	ХҮҮ	0.00	0.00
2111	Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	0.00	0.00
2112	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	0.00	0.00
212	ТАТААС	0.00	0.00
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	0.00	0.00
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	0.00	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	0.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	0.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	0.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		0.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	0.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	0.00
2260	Гадаад эх үүсвэрээр	0.00	0.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.00	0.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	432,508,500.00	502,999,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	432,508,500.00	502,999,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	432,508,500.00	502,999,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2019.02.25	Аудитын нэр:	2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан	Аудитын код:
				САГ-2019/195/СТА-ТШЗ

Шалгагдсан байгууллагын нэр:	Замын-Үүдийн Чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба	Мянган төгрөгөөр
------------------------------	---	------------------

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5	5
1	Тус захирагчийн албанд хяналт, шинжилгээ үнэлгээ, дотоод аудит хариуцсан орон тооны албан тушаалтан ажилладаг сайн талтай бөгөөд харин тайлант жилд хийсэн дотоод аудитын тайлангаас харахад эрсдэлүүдийг төлөвлөлтийн шатанд тодорхойлоогүй, дотоод аудитын тайлангийн загвараар тайлан бичээгүй, өгч байгаа зөвлөмжүүд нэгж, албадуудын холбогдох албан тушаалтнуудад нэр зааж өгдөггүй, дотоод аудит хийх ажил бүр дээр аудитын төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулж батлуулж ажиллаагүй, бүтэц зохион байгуулалтын хувьд хараат бус зарчим алдагдаж байгаа зэрэг нь Дотоод аудитын мэргэжлийн практикийн Олон Улсын стандарт (ДАМПОУС) болон Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан "Дотоод аудитын дүрэм"-ийн 3.1, 4.4, 7.2, 7.3 дахь заалтуудыг тус тус зөрчиж байна.		Зөвлөмж өгсөн	Захирагч Ахлах ня-бо	И.Батнасан Д.Нармандах
2	Чөлөөт бүсийн тухай хууль болон Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 291 дүгээр тогтоолыг үндэслэн Захирагчийн алба аж ахуйн нэгж байгууллагуудад төсөл сонгон шалгаруулах хэлбэрээр газар эзэмшүүлж, газрын төлбөр авч байна. Энэхүү оруулсан орлого батлагдсан төлөвлөгөө байхгүй, зөвхөн урсгал зардлын санхүүжилтын 100900036011 тоот дансанд тайлант жилд нийт 502.9 сая төгрөг төвлөрүүлж, Сангийн яамны Төрийн санд төвлөрүүлжээ.	502,999.00	Зөвлөмж өгсөн	Захирагч Ахлах ня-бо	И.Батнасан Д.Нармандах

**Замын-Үүдийн Чөлөөт бүсийн Захирагчийн Ажлын албаны 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

	Ийнхүү урсгал санхүүжилтийн дүнд оруулан бүртгэж байгаа нь төсвийн тухай хуулиар баталсан төсвийг хэтрүүлсэн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг буруу илэрхийлэхэд хүргэж байна.				
3	Санхүүгийн тайлангийн тодруулгыг хагас дутуу хийж байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8.1.5 дахь заалт болон АОУС 700-ын 14 (а, б) дэх зүйлд заасан “Санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга”-ыг үнэлэх боломжгүй болгож байна.		Зөвлөмж өгсөн	Захирагч Ахлах ня-бо	И.Батнасан Д.Нармандах
4	Сангийн сайдын 2012 оны 76 дугаар тушаалаар баталсан “Төсвийн гүйцэтгэлийн тайлан боловсруулах журам”-ын дагуу 2.3, 2.5-д заасны дагуу Төсөвт байгууллага нь төсвийн гүйцэтгэлийн тохируулгыг маягтын дагуу үнэн зөв гаргаж баталгаажуулахаар заасны дагуу зөв гаргахгүй байна.		Зөвлөмж өгсөн	Захирагч Ахлах ня-бо	И.Батнасан Д.Нармандах
5	Замын-Үүдийн чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт 2008 онд Улсын төсвийн хөрөнгөөр 6 урсгалтай, 1.25 км хатуу хучилттай авто зам тавихад зарцуулж, одоогийн байдлаар ажил бүрэн дуусч 100 хувийн гүйцэтгэлтэй гэх боловч Улсын комисс албан ёсоор хүлээж аваагүй, өмчлөлийн асуудал шийдэгдээгүй, нягтлан бодох бүртгэлд 379.9 сая төгрөгийн “Дуусаагүй барилга байгууламж”-аар бүртгэсээр иржээ. Энэ нь УСНББОУС болон Сангийн сайдын 2016 оны 388 дугаар тушаалаар баталсан “Санхүүгийн тайлангийн аргачлал, зааврыг зөрчсөн байна.	379,935.40	Зөвлөмж өгсөн	Захирагч Ахлах ня-бо	И.Батнасан Д.Нармандах
	Нийт дүн	882,934.40			